



**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
БАЙНГЫН ХОРООНЫ
ТОГТООЛ**

2015 оны 10 сарын 27 өдөр

Дугаар 26

Улаанбаатар хот

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.2.9 дэх заалт, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5 дахь хэсгийг тус тус үндэслэн Хууль зүйн байнгын хорооноос ТОГТООХ нь:

1. Монгол Улсын Засгийн газраас 2015 оны 9 дүгээр сарын 14-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Монгол Улсын хилийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон холбогдох бусад хуулийн төслийг Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх бэлтгэл хангах, санал, дүгнэлтийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай:

Ажлын хэсгийн ахлагч:

Ө.Энхтүвшин - Улсын Их Хурлын гишүүн

Гишүүд:

О.Баасанхүү - Улсын Их Хурлын гишүүн
Л.Болд - Улсын Их Хурлын гишүүн
Ц.Нямдорж - Улсын Их Хурлын гишүүн
Х.Тэмүүжин - Улсын Их Хурлын гишүүн

2. Ажлын хэсэгт мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэх дэд хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай:

Т.Бат-Өлзий - Хууль зүйн яамны Эрх зүйн шинэчлэлийн бодлогын газрын дарга
Ш.Лхачинжав - Хил хамгаалах ерөнхий газрын дарга
Л.Баатарчулуун - Иргэний харьяалал, шилжилт хөдөлгөөний ерөнхий газрын дэд дарга
Т.Нармандах - Хууль зүйн яамны Эрх зүйн шинэчлэлийн бодлогын газрын мэргэжилтэн
Б.Баасандорж - Хууль зүйн байнгын хорооны ахлах зөвлөх
П.Сайнзориг - Хууль зүйн байнгын хорооны зөвлөх
В.Баасанхүү - Хууль зүйн байнгын хорооны референт

ХУУЛЬ ЗҮЙН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА

Д.ГАНБАТ

